

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2026 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/09

Арвайхээр сум

Мэргэжлийн багуудыг шинэчлэн томилох тухай

Монгол Улсын Шадар сайдын 2023 оны “Журам шинэчлэн батлах тухай” 04 дугаар сарын 24-ны өдрийн 28 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 04 дүгээр сарын 21-ны өдрийн “Заавар батлах тухай” 160 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Зоонозын шалтгаант халдварт өвчний тохиолдол буюу тарваган тахал, боом, галзуу, хачгаар дамжих халдвар, бэтэг, урвах тахал зэрэг өвчнүүдийн үйл явдал гарсан үед ажиллах мэргэжлийн багуудын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажиллах чиг үүргийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Мэргэжлийн баг бүрэлдэхүүний зоонозын халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх, оношлох, эмчлэх, халдвар хамгааллын дэглэмийг сахих тусгай сургалт явуулж, дадлага эзэмшүүлэн бэлэн байдлыг хангуулах, удирдлага арга зүйгээр хангаж ажиллахыг Зоонозын өвчин судлалын төв (Б.Сүхбаатар)-д, Бүсийн оношилгоо эмчилгээний төв (Г.Дашжанцан)-д тус тус үүрэг болгосугай.

3. Хавсралтаар батлагдсан эмч, мэргэжилтний томилгоог жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан тодотгож байхыг Зоонозын өвчин судлалын төв (Б.Сүхбаатар)-д даалгасугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга (М.Золзаяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Н.ОЮУНТУЯА



622301045

D:My.Doc Tushaal. EMG

Эрүүл мэндийн газрын даргын
2026 оны 07 дүгээр сарын 10-ны
өдрийн 11 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт



ЗООНОЗЫН ШАЛТГААНТ ХАЛДВАРТ ӨВЧНИЙ
ТОХИОЛДОЛ, ҮЙЛ ЯВДАЛ ГАРСАН ҮЕД АЖИЛЛАХ
МЭРГЭЖЛИЙН БАГУУДЫН БҮРЭЛДЭХҮҮН

№	Мэргэжил	1-р баг	Ажлын газар	2-р баг	Ажлын газар
1	Тархвар судлагч их эмч (ажлын хэсгийн ахлагч)	Э.Лхагвадулам	ЗӨСТ	С.Цэнддулам	ЗӨСТ
2	Халдвар судлагч их эмч	Г.Надмидсүрэн	БОЭТ	Х.Бархасбадь	БОЭТ
3	Халдвартын их эмч	Д.Цэцэгмаа	БОЭТ	П.Лхам	БОЭТ
4	Нян судлагч их эмч	С.Сосорбурам	ЗӨСТ	Н.Гэрэлчимэг	ЗӨСТ
5	Дотрын их эмч	Б.Чулуунгэрэл	БОЭТ	С.Доржхорлоо	БОЭТ
6	Хүүхдийн их эмч	Ш.Жавзансүрэн	БОЭТ	Н.Энхтунгалаг	БОЭТ
7	Биологич	Л.Мэнд-Амар	ЗӨСТ	О.Батдулам	ЗӨСТ
8	Эмгэг анатомийн лаборант	Л.Хорлоо	БОЭТ	Б.Молормаа	БОЭТ
9	Нян судлалын лаборант	Д.Даваадэмбэрэл	ЗӨСТ	Ц.Наранбаатар	ЗӨСТ
10	Клиникийн лаборант	Г.Ариунтунгалаг	БОЭТ	Б.Алтангэрэл	БОЭТ
11	Сувилагч	Г.Отгонсүрэн	БОЭТ	Г.Алтантуяа	БОЭТ
12	Сувилагч	Б.Жавзандулам	БОЭТ	Н.Нармандах	БОЭТ
13	Ариутгагч	М.Буяндэлгэр	ЗӨСТ	Н.Лусмаа	БОЭТ
14	Үйлчлэгч	А.Соёл-Эрдэнэ	БОЭТ	Н.Банзрагч	БОЭТ
15	Үйлчлэгч	Х.Пүрэвдолгор	БОЭТ	Д.Цэвэлсүрэн	БОЭТ
16	Жолооч	Ц.Бямбадулам	ЗӨСТ	П.Сундуйбанзрагч	ЭМГ
17	Жолооч	Т.Дашдорж	БОЭТ	О.Гантөр	БОЭТ

Эрүүл мэндийн газрын даргын
2026 оны 04 дүгээр сарын 04-ны
өдрийн 41 дугаар тушаалын
хоёрдугаар хавсралт



АЖИЛЛАХ ЧИГ ҮҮРЭГ

Нийтлэг үндэслэл

1.1.ЗӨСТ-өөс авч хэрэгжүүлэх арга хэмжээ

1.1.1. Зоонозын халдварт өвчний сэжигтэй тохиолдол илэрсэн үед ЗӨСҮТ-д 2 цагийн дотор яаралтай мэдээлж, ЗӨСТ-ийн мэргэжлийн баг нэн даруй цугларч, эрсдлийн түргэвчилсэн үнэлгээг хийж, эрсдлийн зэргийг тогтоон дуудлагад үйлчлэх ба голомтын хариу арга хэмжээг зохион байгуулан ажиллана.

1.1.2. Зоонозын халдварт өвчний хариу арга хэмжээний үед шаардагдах нөөцийг (хүний нөөц, эм урвалж оношлуур, тэжээлт орчин, халдваргүйтгэлийн бодис, хамгаалах өмсгөл, машин техник, тоног төхөөрөмж, бичгийн хэрэгсэл) төлөвлөн, хангалт хийж, бэлэн байдлыг хангана.

1.1.3. Зоонозын халдварт өвчний сэргийлэлт, хариу арга хэмжээний чиглэлээр бүх шатны Эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн ажилтнуудад онолын болон дадлагажуулах сургалт сургалт зохион байгуулна.

1.1.4. Голомтот нутгийн болон эрсдэлт бүлгийн хүн амд чиглэсэн мэдээлэл сургалт сурталчилгааны ажлыг хэрэгжүүлнэ.

1.2. Эрүүл мэндийн байгууллагаас (БОЭТ, ЭМГ) -аас авч хэрэгжүүлэх арга хэмжээ

1.2.1. Зоонозын халдварт өвчний сэжигтэй тохиолдол, хавьтлыг тусгаарлах, ялган оношлох, өвчтөнг эмчлэх хэсэг бүхий эмнэлгийг зохион байгуулан шаардагдах тоног төхөөрөмж, лабораторийн сорьц авах хэрэгсэл, оношлуур, тэжээлт орчин, эм урвалж зэргээр хангаж бэлэн байдлын нөөцийг бүрдүүлнэ.

1.2.2. Зоонозын халдварт өвчний сэжигтэй тохиолдлын дуудлагад ажиллах эрүүл мэндийн ажилтныг томилж, сургалтад хамруулна.

1.3. Тархвар судлагч эмчийн үүрэг

1.3.1. Тус мэргэжлийн багийг ахалж ажиллана.

1.3.2. Монгол Улсын Шадар сайдын 2023 оны “Журам шинэчлэн батлах тухай” 28 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2017 оны “Заавар батлах тухай” 160 дугаар тушаалыг хэрэгжүүлэн ажиллах.

1.3.3. Зоонозын халдварт өвчний сэжигтэй тохилдлыг илрүүлсэн эмч харьяа эрүүл мэндийн байгууллагын удирдлагад, нийслэлд ХӨСҮТ, ЗӨСҮТ-д мэдээлж, хариу арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлнэ.

1.3.4. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн ажилтан өвчтөнд үзлэг хийх явцад тухайн өвчний тохиолдлын тодорхойлолтод тохирсон хариу арга

хэмжээг зохион байгуулна.

1.3.5.Зоонозын халдварт өвчний голомтод халдваргүй ба халдвартай бүсийг халдвар хамгааллын дэглэмийн дагуу байгуулна.

1.3.6.Голомтоос зайлшгүй гарах шаардлагатай хүмүүсийн эрүүл мэндийг ариун цэврийн нэвтрэх цэгийн дэргэд тусгай байранд ажиглаж, мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн Онцгой комиссын штабын зөвшөөрлөөр гаргана.

1.3.7.Гаднаас ирсэн зайлшгүй орох шаардлагатай хүмүүсийг Онцгой комиссын штабын зөвшөөрлөөр голомтод оруулна.

1.3.8.Тархвар судлагч өвчтөн болон хавьтлуудаас тархвар судлалын судалгаа авч, өвчтөн ба хавьтагсдыг тусгаарлах, ялгах эмнэлэгт хэвтүүлэх ажлыг зохион байгуулна.

1.3.9.Голомтын халдваргүйтгэлд хяналт тавина.

1.3.10.Хүн амд чиглэсэн сургалт сурталчилгааны материал бэлтгэн сурталчлах, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сэрэмжлүүлэг хүргэх ажлыг зохион байгуулна.

1.3.11.Аймгийн ЗДТГ, Мал эмнэлгийн газар, Онцгой байдлын газар, Цагдаагийн газар, Авто тээврийн үндэсний төв шаардлагатай агентлаг газруудтай хамтарч ажиллана.

1.4 Халдвартын их эмчийн үүрэг

1.4.1.Эмнэлзүй болон лабораторийн шинжилгээгээр батлагдсан өвчтөн ба хавьтагсдыг тусгаарлах, ялгах, эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх.

1.4.2.Зоонозын халдварт өвчний тохиолдлын тодорхойлолтоос хамаарч урьдчилан сэргийлэх эмчилгээнд хамруулж хяналтад авна.

1.4.3. Халдвартын эмнэлэг, тусгаарлах эмнэлэгт гадны хүн оруулах, хоол хүнс зөөж эргэлт оруулахыг хатуу хориглож, цагдаагийн байнгын хамгаалалт гаргана.

1.5. Нян судлагч эмч, нян судлалын лаборантын үүрэг

1.5.1.Сэжигтэй тохиолдолд ийлдэс судлалын шинжилгээ, нян судлалын шинжилгээ, бичил харах шинжилгээ, молекул биологийн шинжилгээ, биологийн шинжилгээг хийж үрг дүнг тооцно.

1.5.2.Сорьц авах, дохио шинжилгээ, А шатны шинжилгээ хийж гүйцэтгэж үр дүнг тооцно.

1.6. Дотрын их эмч, хүүхдийн их эмчийн үүрэг

1.6.1.Монгол Улсын Эрүүл Мэндийн Сайдын 2017 оны “Заавар батлах тухай” 160 дугаар тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор ялган оношилгоог хийж гүйцэтгэнэ.

1.7. Эмгэг анатомийн лаборантийн үүрэг

1.7.1.Зоонозын халдварт өвчнөөр нас барсан тохиолдолд холбогдох тушаал зааврын дагуу эмгэг судлалын шинжилгээ хийж тэмдэглэл хөтөлнө, лабораторийн шинжилгээнд сорьц авна.

1.7.2.Эмгэг судлалын шинжилгээг эмгэг судлаач эмч, ЗӨСТ-ийн мэргэжилтнүүдийг байлцуулан хийж гүйцэтгэнэ.

1.8. Ариутгагчийн үүрэг

1.8.1.Халдваргүйтгэлийг тархвар судлагч эмчийн хяналтан дор хийж гүйцэтгэнэ.

1.8.2.Халдваргүйтгэлд хими, физикийн арга ашиглана.

1.8.3.Халдваргүйтгэлийн бодисыг бүлээн усаар найруулж, үйлдвэрлэгчийн зааврын дагуу хэрэглэнэ.

1.8.4.Голомтод байнгын ба эцсийн халдваргүйтгэлийг хийхдээ төрийн захиргааны төв байгууллагаас баталсан заавар, журмыг мөрдөн ажиллах.

---oOo---